

**ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮНИЙГ ОГЦРУУЛАХ ТУХАЙ САНАЛЫГ ХЭЛЭЛЦСЭН
ТАЛААР ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2013 оны 12 дугаар
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн
С.Баярцогт**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн С.Баямбацогт, Сү.Батболд нарын нэр бүхий 26 гишүүнээс Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Ч.Улааныг үүрэгт ажлаас нь огцруулах саналыг 2013 оны 12 дугаар сарын 16-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ.

Энэ асуудлыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаараа Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.3 дахь хэсэгт заасны дагуу хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар асуудлыг хэлэлцэхэд Улсын Их Хурлын гишүүд Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Ч.Улааныг огцруулах саналыг өргөн мэдүүлсэн Улсын Их Хурал дахь МАН-ын бүлэг болон Сангийн сайд Ч.Улаанаас асуулт асууж, хариулт авсан бөгөөд Улсын Их Хурлын зарим гишүүд энэ асуудлаар саналаа хэллээ. Ийнхүү хэлэлцсэний дараа Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Ч.Улааныг огцруулах нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнхи олонхи нь үг саналыг дэмжээгүй болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Ч.Улааныг огцруулах саналыг хэлэлцсэн тухай Төсвийн байнгын хорооноос гаргасан санал дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Ц.ДАВААСҮРЭН